

Шүүхээр гэр бүл цуцлуулах гэж буй гадаадын иргэдэд зориулсан танилцуулга

1. Харилцан тохиролцож гэр бүл салах болон шүүхээр гэр бүл цуцлуулах

- БНСУ-ын иргэний хуулийн дагуу гэр бүл цуцлалтыг харилцан тохиролцсон салалт болон шүүхээр таслуулсан салалт гэж хоёр ангилдаг.
- Эхнэр нөхөр хоёр гэр бүл цуцлуулах, насанд хүрээгүй хүүхдийн асран хамгаалагчаа харилцан тохирсон бол харилцан тохиролцож гэр бүл цуцлуулж болно.
- Эхнэр нөхөр хоёр харилцан тохиролцолд хүрч чадаагүй тохиолдолд шүүхээр таслуулан гэр бүлээ цуцлуулах шаардлагатай.

2. Гэр бүл цуцлуулах зарга үүсгэх

- Эхнэр нөхөр хоёрын хооронд гэр бүл цуцлалт, хөрөнгө хуваах, насанд хүрээгүй хүүхдийн асран хамгаалах эрх, хүүхдийн тэтгэлэг, уулзалттай холбоотой маргаан болон энэхүү гэр бүл салалтад буруутай талд торгууль оногдуулах зорилгоор гаргасан заргыг гэр бүлийн хэрэг хариуцсан шүүхэд үүсгэх шаардлагатай.
- Шүүхээр гэр бүл цуцлуулах явцад хөрөнгө хуваахаас гадна нөхөн төлбөр ногдуулж болно. Хэрэв зарга үүсгэх хүсэлт гаргаагүй тохиолдолд шүүхээс үүнтэй холбоотой шийдвэр гаргахгүй.
- ‘Нөхөн төлбөр’ гэж аль нэг тал нь гэр бүл салалтад хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн ба тухайн талд учирсан бие махбод сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлөхийг хэлнэ.
- ‘Хөрөнгө хуваах’ гэдэг нь гэр бүл салах үед хамтарч бий болгон хадгалж ирсэн дундын өмчийг хуваахыг хэлнэ.
- Хэрэв насанд хүрээгүй хүүхэд байвал нэмж ‘Асран хамгаалагчийг сонгох’, ‘Хүүхдийн тэтгэмж’ болон ‘Хүүхэдтэйгээ уулзах’-тай холбоотой асуудлийг хэлнэ.

3. Шүүхээр гэр бүл цуцлуулах шалтгаанууд


- БНСУ-ын иргэний хуулийн 840-д зааснаар дараах шалтгаануудаас нэгээс дээш нь хүлээн зөвшөөрөгдөж байвал шүүхээр гэр бүл цуцлуулах хүсэлт гаргаж болно.

Иргэний хуулийн 840(Шүүхээр гэр бүл цуцлуулах шалтгаанууд)

Эхнэр нөхрийн аль нэгт нь дараах шалтгаанууд байгаа тохиолдолд гэр бүлийн шүүхэд хандан гэр бүл цуцлуулж болно.

1. Эхнэр эсвэл нөхөр нь зүй бус үйлдэл гаргасан бол
2. Эхнэр эсвэл нөхөр нь санаатайгаар үл тоомсорлох
3. Эхнэр эсвэл нөхөр, түүний хамаатан садан зүй бусаар харьцсан тохиолдолд
4. Өөрийн хамаатан саданд эхнэр эсвэл нөхөр нь зүй бусаар харьцсан тохиолдолд
5. Эхнэр эсвэл нөхрийн амьд эсэх нь 3 жил тодорхойгүй байсан тохиолдолд
6. Гэр бүлийн амьдралаа үргэлжлүүлэх боломжгүй бусад шалтгаанууд байгаа тохиолдолд

4. Зарга үүсгэх болон шийдвэрлэх



5. Шүүхээр гэр бүл цуцлуулах дараалал

А. Өргөдлийн хуулбарыг илгээх

- Гомдол гаргагч этгээд өргөдлөө шүүхэд гаргавал хуулбарыг нь хариуцагч этгээдэд илгээх ба гэрийн хаяг нь тодорхойгүй тохиолдолд тодорхой хугацаанд зарлал гарган мэдэгддэг байна.

Б. Шүүхийн шийдвэрээс өмнө хамгаалуулах хүсэлт гаргах

- Зарга мэдүүлсэн болон эвлэрэхээр болсон боловч үр дүн нь гараагүй байхад яаралтай шаардлага гарсан тохиолдолд хамгаалуулах хүсэлт гаргаж болно.
- Шүүхээс шаардлагатай бол холбогдох этгээд хүсэлт гаргаагүй байсан ч өөрийн эрхийн дагуу хамгаалалтад авах шийдвэр гаргаж болно.
- Хамгаалах хүсэлтийг дараах тохиолдлуудад хүлээн авна.
 - Тухайн этгээдтэй уулзах, ойртохыг хорих шаардлагатай бол
 - Ахуйн зардал болон хүүхдийн тэтгэмжийн мөнгийг авах тохиолдолд
 - Уулзуулах гэж байгаа бол
- Хамгаалах шийдвэр авсанаас хойш 7 хоног дотор яаралтай хүсэлт гаргаж болох ба эцэслэн шийдвэрлэж байж хүчинтэй байна.
- Гэр бүлийн хэрэг дагнасан шүүхээс гаргасан хамгаалах шийдвэрийг зөрчсөн этгээдэд 10 сая вон хүртэл торгууль ногдуулна.

В. Шүүх өдөр

- Өргөдлийн хуулбар холбогдох этгээдэд хүрсний дараа шүүгч шүүх өдрийг тогтоож мэдэгдэнэ. Онцгой шалтгаангүй бол тухайн этгээд заасан өдөр өөрийн биеэр шүүх хуралд оролцох шаардлагатай. Шүүх хуралд дуудсан хуудас авсан хүн онцгой хүндэтгэх шалтгаангүйгээр хуралд ирээгүй бол 500 мянган вон хүртэл торгууль ногдуулна.
- Шүүх хурлын өдөр холбогдох этгээд тус бүр бодит үнэнийг (Жишээ нь: Шүүхээр гэр бүл цуцлуулах шалтгаан болсон бодит үнэнийг) мэдүүлэн, нотлох баримт болон гэрчийг мэдэгдэн шалгуулна.
- Иргэний хэргээс ялгаатай нь гэр бүл цуцлах хэрэг нь зарга гаргагч талд зогсож болох ба холбогдох этгээд хүлээн зөвшөөрөөгүй боловч үнэн байдлыг гол шалтгаанаар авч үзэж болох ба зарга гаргагч талаар уг байдлыг шалгуулдаг. Мөн холбогдох этгээд болон түүний хууль ёсны төлөөлөгчийг нь хэзээ ч шалгаж болно.

Г. Гэр бүлийг байцаан шалгах

- Шүүх газраас шүүх хурлын өмнө шаардлагатай гэж үзвэл гэр бүлийн хэргээр мэргэшсэн байцаагчаар тухайн гэр бүлийг байцаан шалгуулдаг. Мөн эвлэрүүлэх явцад ч байцаан шалгуулж болно.
- Гэр бүлийн хэрэг хариуцсан байцаагч нь сэтгэл мэдрэл, нийгмийн ухаан, эдийн засаг, боловсролтой холбоотой мэргэжлийн чадвараа ашиглан тухайн гэр бүл салах болсон шалтгаан, холбогдох хүмүүсийн боловсрол, ажлын

туршлага, гэр бүлийн байдал, эд хөрөнгө, зан авир, эрүүл мэнд, гэр бүлийн орчны талаар байцаан шалгадаг болно.

- Гэр бүлийг дараах байдлаар байцаан шалгана

. Үнэн байдлыг шалгах: Гэр бүл цуцлах болсон шалтгаан, эхнэр нөхрийн дундын өмчийг хэрхэн бий болгосон, насанд хүрээгүй хүүхдийн асран хамгаалж буй орчин зэргийг байцаах, сэтгэл мэдрэлийн судалгаа хийх гэх мэт.

. Зохицуулах арга хэмжээ: Гэр бүлийн хэрэг байцаагч өөрөө эсвэл бусад холбогдох байгууллагатай холбож сэтгэл мэдрэлийн зөвлөгөө өгөх, эмд донтох болон мөрийтэй тоглоомын донтой тэмцэх, эмчлүүлэх гэх мэт арга хэмжээнүүд орно.

Д. Зохицуулах

- Зохицуулалтын өдөр холбогдох этгээд өөрийн биеэр оролцох ёстой. Мөн зарга гаргагчийн төлөөлөгчтэй хамт оролцож болно.
- Зохицуулах өдөр шүүгч болон зөвлөлийн гишүүдийн шаардлагаар холбогдох этгээдүүд харилцан зохицохоор болвол зохицуулалтыг хийнэ. Зохицуулалтыг бичгээр үйлдэн харилцан тохиролцсон агуулгыг бичиж хоёр этгээдэд илгээнэ.
- Зохицуулж чадаагүй тохиолдолд 'Өөр аргаар зохицуулах шийдвэр (Албан хүчээр зохицуулалт хийх)' гаргаж болно. Хэрэв энэ шийдвэрийг авсанаас хойш 14 хоног дотор дахин зарга гаргаагүй тохиолдолд тухайн шийдвэр хүчинтэй болно.
- Энэхүү зохицуулах шийдвэр нь шүүхийн эцсийн шийдвэртэй ижил үр нөлөөтэй. Тиймээс зохицуулах шийдвэр гарвал холбогдох этгээдүүд шийдвэрийг эсэргүүцэх боломжгүй.


Е. Харилцан эвлэрэх шийдвэр

- Хэргийг хариуцсан шүүх байгууллага зарга үргэлжлэх хугацаанд харилцан эвлэрэх хугацааг тогтоож болно.
- Харилцан эвлэрэх хугацаа өгсөн шийдвэр авсанаас 2 долоо хоногийн дотор хүсэлт гаргаагүй тохиолдолд эвлэрэх шийдвэрийг эцсийн шийдвэрт тооцон шүүх ажиллагаа дуусна.
- Эвлэрэх шийдвэр нэгэнт гарвал холбогдох этгээдүүд үүнийг давж заалдах боломжгүй.

Ё. Шүүхийн шийдвэр

- Шүүхээс шийдвэр гарган хэргийг хаана.

Ж. Давж заалдах



- Анхан шатны шүүхийн шийдвэр гарснаас хойш 2 долоо хоног дотор давж заалдах эрхтэй. Тухайн шийдвэр гаргасан шүүх байгууллагад давж заалдах хүсэлтийг гаргана.
- Давж заалдах хурлын шийдвэр гарснаас хойш 2 долоо хоног дотор дээд шүүхэд дахин давж заалдаж болно. Давж заалдах хурал хийсэн шүүх байгууллагад дахин давж заалдах хүсэлтээ бичгээр өгнө.

- Анхан шатны шүүхийн шийдвэр гарсны дараа давж заалдах хугацаанд давж заалдаагүй болон дахин давж заалдах хугацаанд давж заалдаагүй тохиолдолд анхан шатны шүүхийн шийдвэр хүчинтэй хэвээр байна.
- Нээлттэй шүүх хурлаар шийдвэр нь гарсан зэрэг шалтгаанаар шүүхийн шийдвэр гарсны дараа холбогдогч этгээд шийдвэрийг мэдсэн тохиолдолд өөрөөс шалтгаалаагүй хүндэтгэх шалтгаанаар хуралд оролцож чадаагүй нь нотлогдвол давж заалдаж болно. Үүнийг нөхөн заалдах гэж нэрлэнэ.
- Шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулахгүйгээр ямар нэг үг үсгийн алдаа байвал (иргэний үнэмлэхийн дугаар, хаягийн алдаа г.м) холбогдох этгээд шийдвэр гаргасан шүүх байгууллагад хүсэлт гарган засвар оруулах боломжтой.

3. Шүүхийн шийдвэрийн дараах явц

- Шүүхийн эцсийн шийдвэр гарсан болон зохицуулахаар шийдвэрлэгдсэн ч гэр бүлийн лавлагаанд өөрчлөлт оруулахын тулд шийдвэр гарснаас 1 сарын дотор нотлох бичиг, шийдвэр гарсан тухай албан бичгүүдийг бүрдүүлэх ба зохицуулалтаар шийдвэрлэгдэх болсон бол 1 сарын дотор батлах баримтыг өөрийн бүртгэлтэй захиргааны нэгжид очиж бүртгүүлнэ.
- Шүүхийн шийдвэр гарсныг батлах бичиг, шүүх хурал явагдсан тухай батлах бичгүүдийг тухайн шүүх байгууллагаас авч болно.

6. Иргэншил авах болон оршин суух эрх

- Иргэншил авах, оршин суух эрх нь шүүх байгууллагатай хамааралгүй бөгөөд хууль зүйн яамнаас хамаардаг болно.

- Иргэншил авах, оршин суух эрхтэй холбоотой Хууль зүйн яамны харъяа Гадаадын иргэдийн оршин суух, цагаачлах асуудал эрхэлсэн бодлогын газрын цахим хуудаснаас(www.immigration.go.kr) мэдээлэл авч болно.

7. Гадаад иргэдэд зориулсан орчуулга, зарга үүсгэх тогтолцоог мэдээлэх

А. Орчуулагч гаргаж өгөх

- Гэр бүлийн хэрэг хариуцсан шүүхээс солонгос хэл мэдэхгүй хүнд орчуулагч олж өгч төлбөрийг нь гаргаж байгаа болно. Шүүх хурлын өдөр орчуулагчтай ирэх боломжгүй тохиолдолд урьдчилан орчуулагч авах хүсэлтээ гаргахыг хүсье.

Б. Хөрөнгө мөнгөний бололцоогүй хүнд хууль эрхийн үйлчилгээг үнэгүй өгөх

- Энэ тогтолцоо нь зарга үүсгэхэд шаардагдах зардлыг өөрөө төлөх боломжгүй хүмүүст зориулж улсаас төлбөрийн тодорхой хэсгийг төлж өгдөг тогтолцоо юм.
- Үүнд дараах төлбөрүүд орох ба марк, шуудангаар илгээх зардал, орчуулагчийн хөлс, хөрөнгө тогтоох төлбөр, өмгөөлөгчийн хөлс зэрэг багтана.

В. Гадаадын иргэдэд зориулсан үнэ төлбөргүй өмгөөлөгчийн тогтолцоо

- ‘Сөүлийн гэр бүлийн хэрэг шийдвэрлэх ерөнхий шүүх’-ээс Сөүл дахь өмгөөлөгчдийн холбооны тусламжтайгаар энэхүү тогтолцоог хэрэгжүүлж

байгаа юм. Хэрэв гадаадын иргэн шүүхээс асуувал хариуцсан газрыг нь зааж өгсөнөөр илүү түргэн бас чирэгдэлгүйгээр дээрх тогтолцоонд хамрагдан өмгөөлөгч авах боломжтой.

- Гадаадын иргэдэд зориулсан энэхүү үйлчилгээгээр дамжуулан нэг цэгээс хууль эрхийн үйлчилгээг авч болох давуу талтай болно.